



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 368

Улаанбаатар хот

“Өмгөөлөл хууль зүйн билиг консалтинг” БН-ийг
үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх
хуулийн компаниар бүртгэх тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай” журмын 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь :

1. “Өмгөөлөл хууль зүйн билиг консалтинг” БН-ийг үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх хуулийн компаниар 3 жилийн хугацаагаар бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Өмгөөлөл хууль зүйн билиг консалтинг” БН /Т.Дэлгэрбаяр/-т үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавин олон нийтэд мэдээлэж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

Монгол Улсын
Засгийн
Их Хурал
000012